


2011 ОНЫ
ВИЗ
ОЛГОХ
ЖУРАМ

1. Визний материал мэдүүлэх журмын тухай

А. Визний материал хүлээн авах байгууллага

□ 2011.1.10(Даваа)-ны өдрөөс эхлэн БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам болон тус ЭСЯ-аас хүлээн зөвшөөрсөн визний мэдүүлэг хүлээн авах ажлыг төлөөлөн гүйцэтгэх байгууллагад визний материал мэдүүлэх боломжтой.



Элчин Сайдын Яаманд визний материал мэдүүлэх

* Долоо хоног бүрийн Мягмар гарагт 10:00~12:00 цагийн хооронд авна

Төлөөлөн гүйцэтгэх байгууллагад визний материал мэдүүлэх

* Ажлын өдрүүдэд төлөөлөн гүйцэтгэх байгууллагын тогтоосон цагийн хуваарийн дагуу визний материал хүлээн авна

Б. Визний материал мэдүүлэх дэс дараалал





• • • • **Визний анкет бөглөх**

- Визний анкетыг ЭСЯ болон Төлөөлөн гүйцэтгэх байгууллагуудад байрлуулна.
- Монгол хэл дээрх виз олгох журам (ЭСЯ-ны цахим хуудасны монгол хэл дээрх цонхноос)-ыг татаж авч болно.
- БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны вэб хуудас : <http://mng.mofat.go.kr>

• • • • **Зорчих ангиллын дагуу бичиг баримтыг бүрдүүлэх**

- Зорчих ангиллын дагуу холбогдох бичиг баримтыг бүрдүүлж хавсаргана. (Ангилал тус бүрээр нь тусгайлан хавсаргасан)
- Монгол хэл дээрх бүх бичиг баримтыг солонгос хэлээр орчуулах шаардлагатай
(Нийгмийн даатгал болон хадгаламжийн дэвтрийн хуулбарыг орчуулах шаардлагагүй)

• • • • **Визний материал шалгах хураамж төлөх**

- Визний материал шалгах хураамжийг ХААН банкинд виз мэдүүлэгч өөрийн биеэр очиж тушаан, баримтыг визний материал мэдүүлэхдээ хамт өгнө.

◆ Визний материал шалгах хураамж

- 90 хоног хүртэлх хугацаатай нэг удаагийн визний хураамж :

30 ам доллар


- 90 хоногоос дээш хугацаатай нэг удаагийн визний хураамж :

50 ам доллар

- Олон удаагийн визний хураамж : 80 ам доллар

◆ ХААН банкны (бүх салбар) дансны дугаар:

5038005602 (Хүлээн авагч : БНСУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ)



• • • • **Визний материал мэдүүлэх**

- Визний материалыг мэдүүлж олгосон бүртгэлийн дугаараар визний хариуг авна.

• • • • **Визний ярилцлага**

- Их дээд сургуульд суралцах(D-2), Хэлний бэлтгэлд суралцах(D-4), Солонгосын иргэнтэй гэр бүл болох(F-2) зорилгоор виз мэдүүлэгчтэй ярилцлага хийнэ.
- Ярилцлаганы цагийг виз мэдүүлэгчид утсаар мэдэгдэнэ.
- Ярилцлаганд ирэхдээ бүртгэлийн дугаар, биеийн байцаалтыг авч ирнэ.

• • • • **Визний материалыг шалгаж хариу олгох**

- Богино хугацааны виз 2 долоо хоног, гэрлэлтийн виз 1-3 сарын дараа хариу олгогдоно.
(Визний материал шалгах хугацаа нь материал мэдүүлсэн газартай хамааралгүй)
- Визний материалыг шалгаад виз дарагдсан гадаад паспортыг виз мэдүүлэгчид буцаан олгоно.
- ※ ЭСЯ-нд мэдүүлсэн визний хариу : Долоо хоног бүрийн Мягмар гарагт 16:00-18:00 цагийн хооронд олгоно
- Виз олгохоос татгалзсан хариу авсан иргэд тодорхой хүндэтгэх шалтгаангүй тохиолдолд хариу авсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд виз мэдүүлэх боломжгүйг анхаарна уу.

2011 ОНЫ
ВИЗ
ОЛГОХ
ЖУРАМ

2. Визний тухай ерөнхий мэдээлэл

В. Нийтлэг үндэслэл

БНСУ-д зорчиж буй иргэдийн визний ангилал нь ерөнхийдөө дараах байдлаар ангилагдана

Богино хугацааны нэг удаагийн виз

- ① Бизнес (С-2) : Оршин суух хугацаа 90 хоног
- ② Богино хугацааны нийтлэг статус (С-3) :
Оршин суух хугацаа 90 хоног
(Аялал жуулчлал, төрөл садныд зочлох, хурал семинарт оролцох, эмчилгээ гэж мэт)
- ③ Их дээд сургуульд суралцах (D-2) :
Оршин суух хугацаа 6 сараас 1 жил
- ④ Хэлний курс (D-4) :
Оршин суух хугацаа 6 сар
- ⑤ Гэрлэлт (F-2) Оршин суух хугацаа 90 хоног
Солонгост очоод гадаадын иргэний үнэмлэх авсан тохиолдолд урт хугацааны оршин суух визээр солих боломжтой
- ⑥ Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах (E-9) :
Оршин суух зөвшөөрлийн хугацаанд
- ⑦ Бусад

Олон удаагийн зорчих виз

- Бизнес (С-2) болон Богино хугацааны нийлэг статус (С-3) визний хувьд хүчинтэй хугацаа нь 1 жил болно



※ Дээрх ангиллын визнээс бусад мэдээллийг ЭСЯ-ны 328898 дугаарын утаснаас лавлана.

Е-9 ангиллын Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаас бусад тохиолдолд Солонгост ашиг олох зорилгоор ажил хөдөлмөр эрхлэх нь оршин суух ангилалд харшилсан үйлдэл юм.

Ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор Солонгос руу зорчих гэж буй нь тогтоогдсон тохиолдолд виз олгохоос татгалзана.

Г. Визгүйгээр БНСУ-д зорчих тохиолдолд : **Оршин суух хугацаа 30 өдөр**

▶ Дипломат болон албан паспорт эзэмшигч

▶ Сүүлийн 2 жилийн хугацаанд 4-ээс дээш удаа эсвэл нийт 10-аас дээш удаа ямар нэгэн асуудалгүйгээр БНСУ-д зорчсон иргэн

▶ Дамжин өнгөрөх
(5 улсын хувьд хүлээн зөвшөөрнө)

- АНУ, Япон, Австрали, Шинэ Зеланд, Канад улсын визтэй Монгол Улсын иргэн эдгээр оронд зорчихын тулд БНСУ-аар дамжин өнгөрөх эсвэл дээрх орноос БНСУ-аар дамжин Монгол Улсад буцаж ирэх тохиолдолд 30 хоног хүртэл БНСУ-д визгүй зорчих эрхтэй .

※ Хилийн Шалганаас шалгах үед зорчих орон хүртэлх онгоцны билетийг үзүүлэх шаардлагатай.

Д. Олон удаагийн зорчих виз

▶ Олон удаагийн виз мэдүүлэгчид богино хугацааны бизнес(С-2) болон богино хугацааны нийтлэг статус (С-3) ангиллын виз олгогдоно.

▶ Олон удаагийн виз мэдүүлэгч нь өөрийн хамрагдах ангиллын дагуу нотлох бичиг баримтаа бүрдүүлж өгөх шаардлагатай.

▶ **Олон удаагийн зорчих визний хураамж :**
80 ам доллар ◀

※ Доорх тохиолдолд **1 удаа зорчихдоо 90 хүртэлх хоног(Хүчинтэй хугацаа 1 жил)** виз мэдүүлнэ.

- Эмчилгээ болон амралт сувилалын зорилгоор Солонгосын эмнэлэг, сувиллын газарт хэвтэж эмчлүүлэх гэж буй өвчтөн
- Өвчтөнийг асран хамгаалах зорилгоор Солонгос улсад зорчиж буй өвчтөний эхнэр, нөхөр, үр хүүхэд, төрөл садан

Дараах нөхцөлд **1 удаа зорчихдоо 30 хүртэлх хоногийн виз (Хүчинтэй хугацаа 1 жил)** мэдүүлэх боломжтой .

- ① Төрийн албан хаагч эсвэл төрийн өмчит аж ахуйн нгэжид ажиллаж буй хэлтсийн дарга ба түүнээс дээш албан тушаалтан
- ② БНСУ-д тогтмол нислэг үйлддэг агаарын тээврийн компанийн үйлчлэгч мөн хэлтсийн дарга ба түүнээс дээш албан тушаалтан
- ③ БНСУ-д сүүлийн хоёр жилийн дотор дөрвөөс дээш удаа эсвэл нийт таваас дээш удаа зорчсон хүн
- ④ БНСУ-тай хамтран эрдэс баялаг, эрчим хүч олборлох, борлуулах зорилгоор аж ахуйн нэгж байгуулах мөн БНСУ-ын улсын аж ахуйн нэгж, байгууллагын урилгаар солонгост зорчин, гэрээ хэлэлцээр хийх гэж буй хүн
- ⑤ БНСУ-ын иргэнтэй гэр бүл болсон МУ-ын иргэн ба түүний үр хүүхэд
- ⑥ OECD (Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага)-ын гишүүн оронд оршин суух зөвшөөрөлтэй иргэн мөн OECD-ын гишүүн оронд (БНСУ-аас бусад) сүүлийн хоёр жилд хоёроос дээш удаа зорчсон хүн
- ⑦ Олон улсын төлбөрийн кредит карт эзэмшигчид дотроос VIP хэрэглэгч (“Gold”, “Platinum” карт эзэмшигч)
- ⑧ Төр засгийн тусгай болон өндөр албан тушаалтны хувьд Дипломат төлөөлөгчийн газрын даргын хүлээн зөвшөөрч буй хүн (Үүнд: Томоохон аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагатай ажилтан хамрагдана)
- ⑨ Бизнес(С-2), Богино хугацааны нийтлэг статус (С-3)-ын олон удаагийн зорчих визтэй хүний эхнэр, нөхөр, насанд хүрээгүй хүүхэд

► Виз мэдүүлэгч БНСУ-д өмнө нь зорчиж байхдаа БНСУ-ын Хилийн Шалган Нэвтрүүлэх Албанаас торгууль болон түүнээс дээш хэмжээний шийтгэл авсан тохиолдолд олон удаагийн зорчих виз олгогдохгүй.

Е. Визний мэдүүлэг хүлээн авах ажлыг төлөөлөн гүйцэтгэх байгууллага

- БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам нь визний мэдүүлэг хүлээн авах ажлыг төлөөлөн гүйцэтгэх байгууллагыг сонгон тогтоож, удирдан чиглүүлнэ.
- Төлөөлөн гүйцэтгэх байгууллага нь БНСУ-ын ЭСЯ-наас тогтоосон хэмжээний хүрээнд үйлчилгээний хураамжийг авна.
- Төлөөлөн гүйцэтгэх байгууллага нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн хураамж авах буюу дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох журмын дагуу хариуцлага тооцно.
- Визний мэдүүлэг хүлээн авах ажлыг төлөөлөн гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны ерөнхий чиглэл нь дор дурдсаны дагуу байна:
 - ① Визний материалыг бүртгэн авч ЭСЯ-нд хүлээлгэн өгнө
 - ② Визний материал шалгагдсаны дараа гадаад паспортыг буцаан олгоно.
 - ③ Визний талаарх мэдээллийг өгнө

Ё. Виз олгох зөвшөөрлийн дугаар

БНСУ-ын Хилийн шалган нэвтрүүлэх албанаас олгосон виз олгох зөвшөөрлийн дугаар авсан тохиолдолд

- БНСУ-ын Хилийн шалган нэвтрүүлэх албанаас олгосон зөвшөөрлийн дугаартай тохиолдолд визний анкет болон хураамж, гадаад паспорт(хуулбар), визний зөвшөөрлийн дугаарын хамт мэдүүлж виз авна.
- Визний зөвшөөрлийн дугаартай хүмүүс төлөөлөн гүйцэтгэх байгууллагаар дамжихгүй БНСУ-ын ЭСЯ-нд ирж виз мэдүүлэх ёстойг анхаарна уу. (ЭСЯ-ны ажлын цагаар материал хүлээн авах боломжтой)
- ✳ Визний зөвшөөрлийн дугаарыг анкетны баруун дээд хэсэгт тэмдэглэнэ.

2011 ОНЫ
ВИЗ
ОЛГОХ
ЖУРАМ

3. Визний ангиллын тайлбар болон шалгуурын түвшин

Зорчих ангилал	Харьяалагдах хүн	Шалгуурын түвшин
<p>БИЗНЕС (С-2)</p>	<p>- Гадаадын компани Солонгост төлөөлөгчийн газар нээх, Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Солонгост үүсгэн байгуулах гэж буй хүн - Худалдаа наймаа хийж хувиараа бизнес эрхлэгч - Солонгосын төрийн болон хувийн байгууллагын урилгаар гэрээ хэлцэл хийх гэж буй хүн - Техник тоног төхөөрөмжийн импорт, экспортын үйл ажиллагаа эрхлэгч, холбогдох хүмүүс/Угсрах, хянах зэрэг ажил эрхлэн цалин хөлс авах тохиолдолд хамрагдахгүй/ ※ Үйлдвэрийн газар ажиллах хүч хангах болон мэргэжил дадлага эзэмших зорилгоор сургалтанд хамрагдах тохиолдолд нэг удаагийн виз олгохгүй</p>	<p>- Зах зээлийн судалгаа, гэрээ хэлцэл байгуулах, худалдаа наймаанаас бусад автомашин задлах болон ачих зэрэг хөдөлмөр эрхлэх хэлбэрийг хүлээн зөвшөөрөхгүй - Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, Улсын татварын газраас авсан тодорхойлолтон дээрх татвар төлөлтийн хэмжээгээр тухайн байгууллагын идэвхитэй үйл ажиллагааг тодорхойлж, удирдлагын олгосон албан томилолтын бичиг, ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрээр тухайн байгууллагын ажилтан гэдгийг батлах шаардлагатай - Бизнесийн зорилгоор дахин зорчих гэж буй тохиолдолд өмнөх явалтын бараа бүтээгдэхүүн худалдан авсаныг нотлох баримт хавсаргах шаардлагатай.</p>
<p>Богино хугацааны нийтлэг статус (С-3)</p>	<p>- Аялал жуулчлал, дамжин өнгөрөх, эмчилгээ, төрөл садныд зочлох, нөхөрсөг тоглолт хийх, төрөл бүрийн үйл ажиллагаа, хурал семинарт оролцох, соёл урлаг, дадлага, сургалтанд хамрагдах, шашны арга хэмжээнд оролцох, эрдэм шинжилгээний материал цуглуулах болон бусад зорилгоор богино хугацаанд зорчих хүн / Зорилго нь ашгийн төлөө бол хамрагдахгүй/</p>	<p>▶ Аялал жуулчлал : - Аялан жуулчлах санхүүгийн өндөр чадавхитай эсэх ▶ Төрөл садныд зочлох, хуримын ёслолд оролцох : - Санхүүгийн чадавхи болон төрөл садны холбоог нарийвчлан гаргасан байх ▶ Хурал, семинар, арга хэмжээнд оролцох : - Уригч болон уригдагчийн ажил төрлийн холбоо(ижил төрлийн үйл ажиллагаа эрхлэх), Уригдагчийн мэргэжил (нийгмийн даатгалд хамрагдсан эсэх) ▶ Эмчилгээний зорилгоор зорчих : - Эмчилгээний зорилго үнэн бодит байдал, санхүүгийн өндөр чадавхитай эсэх</p>

		<p>► Монгол дахь Солонгосын хөрөнгө оруулалттай компаний ажилтан Солонгост зорчих :</p> <p>- Тус компанид ажиллаж буй эсэх, аялалын зорилго</p>
Их дээд сургуульд суралцах (D-2)	- Техник мэргэжлийн коллежээс дээш боловсрол, эрдэм шинжилгээний байгууллагаас зөвшөөрөгдсөн бакалавр, магистр, докторын сургалтанд суралцах буюу эрдэм шинжилгээний судалгаа хийх гэж буй хүн	<p>- Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургууль төгссөн диплом болон дүнгийн хуулбар жинхэнэ эсэх</p> <p>- Суралцах болсон шалтгаан болон суралцах төлөвлөгөө хир бодитой, үндэслэлтэй эсэх</p> <p>- Сургууль төгссөн дүн, хэлний чадвар болон суралцах чадвар</p> <p>-Сургалтын зардлыг төлөх санхүүгийн чадавхи</p> <p>※ Визний ярилцлага хийнэ</p> <p>※ Харьяа сургуулиасаа суралцах зөвшөөрлийн бичиг авсан байсан ч визний ярилцлагаас шалтгаалан виз олгогдохгүй татгалзсан хариу гарч болохыг анхаарна уу</p>
Хэлний курс (D-4)	- Их дээд сургуулийн харьяа хэлний курст суралцаж буй хүн - Их дээд сургууль(D-2)-ийн түвшинд нийцэх байгууллага, эрдэм шинжилгээний хүрээлэн болон бусад боловсролын байгууллагад суралцаж буй хүн	<p>- Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургууль төгссөн диплом болон дүнгийн хуулбар жинхэнэ эсэх</p> <p>- Хэлний курст суралцах болсон шалтгаан болон төгссөний дараах суралцах төлөвлөгөө хир бодитой, үндэслэлтэй эсэх</p> <p>-Сургууль төгссөн дүн болон суралцах чадвар</p> <p>-Сургалтын зардлыг төлөх санхүүгийн чадавхи</p> <p>※ Визний ярилцлага хийнэ</p> <p>※ Харьяа сургуулиасаа суралцах зөвшөөрлийн бичигтэй байсан ч визний ярилцлаганы үр дүнгээс шалтгаалан виз олгогдохгүй татгалзсан хариу гарч болохыг анхаарна уу</p>
Гэрлэлт (F-2)	- Солонгосын иргэн болон байнгын оршин суух эрх (F-5) бүхий хүний эхнэр, нөхөр болон насанд хүрээгүй хүүхэд	<p>- Гэрлэлтийн үнэн бодит байдал</p> <p>- Бүрдүүлсэн материалын үнэн зөв эсэх</p> <p>- Гэр бүл болоод амьжиргаагаа авч явах санхүүгийн бодит чадавхитай эсэх</p> <p>※ Визний ярилцлага хийнэ</p>